

НИЙТИЙН ХЭВ ЖУРАМ ХАМГААЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЭРХ ЗҮЙН ОРЧИНГ САЙЖРУУЛАХАД АНХААРАХ АСУУДАЛ

3.Зундуй

Дотоод хэргийн их сургуулийн Удирдлагын академийн 8011 дүгээр дамжааны магистрант, цагдаагийн хошууч

Товч агуулга: Цагдаагийн байгууллагын олон талт үйл ажиллагаа сайтар журамлагдан эрх зүйн орчинд хэрэгждэг. Тэр тусмаа цагдаагийн байгууллагын нийтийн хэв журам хамгаалах өдөр тутмын үйл ажиллагаа, алба хаагчийн мэргэжлийн хүрээнд өрнөх учиртай.

Цагдаагийн байгууллага нь тусгай чиг үүрэг бүхий мэргэжлийн байгууллага бөгөөд тус албанаас явуулах нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийн эрх зүйн орчныг сайжруулах, илүү боловсронгуй болгох асуудал тулгардаг. Эрх зүйн актыг боловсруулах, бүртгэх, хэрэгжилтийн байдалд дүн шинжилгээ хийхэд зарим дүрэм, журам, заавар илтэд хуучирч шинэ тутам бий болсон эрх зүйн харилцааг зохицуулж чадахгүй болсон, эрх зүйн хийдэл, давхардал, зөрчил ихэссэн зэрэг нэн даруй шийдвэрлэвэл зохих асуудалтай тулгарсан. Үүнээс үүдэн цагдаагийн байгууллагын алба хаагчид нийтийн хэв журам сахиулах үедээ хуулийг буруу хэрэглэх, үүний улмаас иргэд хохирох, алба хаагчийн өөрийнх нь эрх ашиг хөндөгдөх явдал олонтаа гарч байна.

Энэхүү илтгэлээр Цагдаагийн байгууллагаас нийтийн хэв журам сахиулах үед ашиглаж буй хамгийн гол эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийхийг зорилоо.

Түлхүүр үгс: Нийтийн хэв журам, эрх зүй, боловсрол, алба хаагч, шийдвэр.

Key words: Public order, law, education, civil servants, decisions.

Оршил. Монгол Улсын цагдаагийн байгууллага, алба Үндсэн хууль, Монгол Улсын хаагчид олгогдсон эрх хэмжээний Засгийн газрын тухай хууль, Засгийн хүрээнд нийтийн хэв журам газрын агентлагийн эрх зүйн сахиулахдаа тодорхой бүрэн эрхийг байдлын тухай хууль, Цагдаагийн хэрэгжүүлдэг. Цагдаагийн албаны тухай хууль болон байгууллага нь алба хаагчдаас холбогдох бусад хууль тогтоомжоор нийтийн хэв журам хамгаалах бүрэн

эрхээ хэрэгжүүлэх, хууль тогтоомжийг хэрэглэх явцад баримталбал зохих хэм хэмжээг тодорхойлох, хуульд заасан эрх хэмжээгээ хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэн ирсэн түүхтэй. Алба хаагчид хууль тогтоомжоор олгогдсон эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байгаагаа ойлгож, ухамсарласан байх ёстой.

Цагдаагийн алба нь нийтийн хэв журам хамгаалах чиг үүргийн хүрээнд хуулиар харьяалуулсан хууль тогтоомж, нийтээр дагаж мөрдөх дүрэм, журмыг сахиулж, захиргааны хяналтын үүргийг хангуулан, гэмт хэрэг, зөрчлийн тоо бүртгэл, судалгаанд үндэслэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилансэргийлэх, эргүүлийн үүрэг гүйцэтгэх, замын хөдөлгөөнийг зохицуулах зэргээр нийтийн хэв журмыг хамгаалж, хуулиар харьяалуулсан зөрчлийг шалгаж шийдвэрлэх, олон нийтийн цагдааг мэргэжил, арга зүйгээр хангах зэрэг ажиллагааг явуулна.

Нэг: Нийтийн хэв журам хамгаалах салбарын эрх зүйн үндэс

Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлд Засгийн газар нь "Хүний эрх, эрх чөлөөг хамгаалах, нийгмийн хэв журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх

арга хэмжээ авч хэрэгжүүлнэ"⁶⁵ гэж заасан.

"Цагдаагийн албаны тухай хууль"-ийн 3 дугаар зүйлд "Цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүрэг бүхий хууль сахиулах байгууллага мөн" гэж тодорхойлсон нь цагдаагийн байгууллага нийтийн хэв журам сахиулах үүрэгтэй байгууллага болж байна.

Тэгвэл 1993 оны цагдаагийн байгууллагын тухай хуулиар тодорхойлж байсан нийгмийн хэв журам, 2013 оны цагдаагийн албаны тухай хуулиар тодорхойлсон нийтийн хэв журам, тэдгээрийн харилцан хамаарлыг харьцуулан үзэх нь зүйтэй.

Хууль зүйн шинжлэх ухааны доктор (Sc.D) Ж.Долгорсүрэн 2004 оны "Монгол Улсын цагдаагийн эрх зүй"⁶⁶ номондоо нийгмийн хэв журам, нийтийн аюулгүй байдал гэсэн тодорхойлолт өгсөн нь 2013 онд батлагдсан "цагдаагийн албаны тухай хууль"-ийн 10 дугаар зүйлд "нийтийн хэв журам хамгаалах", 11 дүгээр зүйлд "Олон нийтийн аюулгүй байдлыг хангах" чиг

⁶⁵ МУ-ын Үндсэн хууль, УБ, 1992 он, Төрийн мэдээлэл эмхтгэл №2.

⁶⁶ Ж.Долгорсүрэн, Монгол Улсын Цагдаагийн эрх зүй, УБ, 2004 он, 36-40 дэхь тал.

үүргүүдтэй дүйцүүлэн ойлгож болох юм. Тухайлбал:

Нийгмийн хэв журам нь хүний ухамсарт амьдралын үр дүн болох зан үйл, үйлдлээр илрэх хүмүүсийн хүсэл зоригийн харилцаанаас бүрэлдэн бий болно.

Улс төрийн тогтолцоо, нийгмийн хэв журмыг хэлбэржүүлэн зан үйлийн социали журмыг тогтоох, түүний биелэлтийг хангах, сахиулах замаар нийгмийн харилцаанд идэвхтэй нөлөөлнө.

Үүнээс үүдэн нийгмийн хэв журам нь нийгэм, төрийн тогтолцоонд баталгаажин нийгмийн харилцааг социали хэм хэмжээ (эрх зүйн, ёс суртахууны, зан заншлын, хамтын аж байдлын, бүх нийтээр дагаж мөрдөх хэм хэмжээ гэх мэт)-гээр хэлбэржүүлэн бүрэлдүүлж тогтоосон нийгмийн учир шалтгаан үндэс бүхий социали эрх зүйн ухагдахуун юм гэж ойлгож болох юм.

Нийгмийн хэв журмын талаар хууль зүйн шинжлэх ухааны доктор, профессор Г.Совд “Нийгмийн хэв журам гэж хүн амын аж төрөн амьдрах, ажил хөдөлмөр эрхлэх, ёс заншил, бүх нийтээр хүлээн зөвшөөрч хэвшсэн буюу хуулиар тогтоосон нийгмийн хэм

хэмжээний нийлбэр цогц”⁶⁷ гэж нийгмийн харилцааны шинжээр нь тодорхойлжээ.

Цагдаагийн эрх зүйн ном зохиолд⁶⁸ нийгмийн хэв журмыг өргөн болон явцуу утгаар тодорхойлж, нийгмийн хэв журам, олон нийтийн хэв журам гэж хоёр зааглан ялгаж үздэг.

Нийгмийн хэв журам гэдэг нь өргөн утгаараа хүмүүсийн хоорондоо харилцах явцад хүн амын амгалан тайван байдал, иргэдийн ая тухтай амрах, хөдөлмөрлөх бололцоог хангах, нийтийн захиргаа, төрийн ба төрийн бус байгууллагын хэвийн ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилготой иргэний нийгмийн хэрэгцээт шаардлагатай нөхцөлдөн гарсан, монголын ард түмний эрх ашигт нийцэх зан заншил, уламжлал, ёс суртахуун, эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй харилцааны бүхэллэг тогтолцоо мөн.⁶⁹

Нийгмийн амьдралын хүрээ, аль нэг салбар дахь нийгмийн харилцааны олон тал, өвөрмөц онцлог байдалтай зохицож, тэдгээрийг тохируулагч эрх зүйн хэм хэмжээ боловсронгуй болсон, нийтийн хэв журамд халдсан эрх зүйн зөрчилд хүлээлгэх хариуцлагыг

⁶⁷ Г.Совд, Монгол Улсын Үндсэн хуулийн нэр томъёоны дагалга. УБ, 1993.

⁶⁸ Ж.Долгорсүрэн. Монгол Улсын Цагдаагий эрх зүй. УБ. 2003 он. 14 дахь тал. Д.

Таванжин. Монгол Улсын Цагдаагийн эрх зүй. УБ., 2006 он. 45-дахь тал.

⁶⁹ Ж.Долгорсүрэн, Д.Булган нарын Монгол Улсын Цагдаагий эрх зүйн курс. УБ. 2014 он. 35 дахь тал

хуулиар тогтоосон, түүнчлэн нийтийн хэв журам хамгаалах чиг үүрэг, түүнийг хэрэгжүүлэх байгууллагатай уялдан олон нийтийн хэв журмыг явцуу утгаар авч үзэх зүй ёсны шаардлага тавигдсан байна.

Олон нийтийн хэв журмыг зөвхөн олон нийтийн газар хүмүүсийн хоорондоо харилцах явцад бүрэлдэн тогтсон нийгмийн харилцааны нэг хэсэг тогтолцоо гэж ойлгоно.

Эдгээр тодорхоллолтоос харахад 2013 онд батлагдсан "Цагдаагийн албаны тухай хууль"-иар тодорхойлогдсон "нийтийн хэв журам" гэсэн нэр томъёог нийгмийн хэв журмын явцуу тодорхойлолт буюу олон нийтийн хэв журамтай дүйцүүлэн ойлгож болохоор байна.

**Хоёр: Нийтийн хэв журам
хамгаалах салбарын
нэр томъёоны тайлбар**

Нийтийн хэв журмыг олон улсын хэллэгт "Public order" гэх бөгөөд "нийтийн хэв журам", "нийгмийн хэв журам", "нийгмийн дэг журам" гэх зэргээр орчуулагддаг. Үүнийг тайлбарлахдаа "Нийтийн орон зай дахь иргэдийн тайван, эмх цэгцтэй зан байдал" буюу үндсэндээ эмх замбараагүй байдал байхгүй

байхыг хэлнэ гэж тодорхойлжээ. Энэ нь хүмүүс мэдрэмжтэй, зохистой харьцаа, бусдад хүндэтгэлтэй хандах явдал юм.

Цагдаагийн байгууллагын үүрэг нь үндсэндээ гэмт хэрэг сөнөөгч гэж хэлж болохоор байна. Өөрөөр хэлбэл цагдаагийн ажилтнууд бүрэн эрхт улсаа энх тайван байлгахаар тангараг ергөж, амар амгаланг хангаж "олон нийтийн хэв журам" хадгалахтай адилтгаж болно.

Харин үүнийг зөрчсөн үйлдлийг гадаадын улс оронд янз янзаар буюу нийгмийн хэв журмын зөрчил, нийгмийн тогтсон хэм хэмжээний эсрэг үйлдэл (antisocial behaviour, антисоциальное поведение), олон нийтийн эсрэг үйлдэл (Anti-social Behaviour order), нийгмийн ёс суртахууны эсрэг үйлдэл (Закон Украины "О защите общественной морали")⁷⁰ гэх зэргээр нэрэлдэг байна.

Ийнхүү улс оронд янз янзаар тайлбарлах боловч ерөнхийд нь авч үзвэл эрх зүй, ёс зүй ёс суртахуун болон соёлын хэм хэмжээнд нийцэхгүй үйл байдал буюу тухайн нийгэмд, тухайн цаг үед тогтсон хэм хэмжээнээс гажууд аливаа үйлдлийг хэлнэ гэж тодорхойлж болох юм. Харин үүнийг монголд захиргааны

⁷⁰ Ж.Долгорсүрэн, Д.Булган нарын Монгол Улсын Цагдаагий эрх зүйн курс. УБ. 2014 он. 36 дахь тал

зөрчил, хэв журмын зөрчил гэж нэрэлдэг.

Монгол Улсын хувьд нийгмийн хэв журмыг онолын хувьд өргөн болон явцуу утгаар тодорхойсон байх боловч нийтийн хэв журмын талаар тодорхойлолт өгөөгүй.

Дээрхи бүгдээс үндэслэн хэлвэл "нийтийн хэв журам" нь нийгмийн хэв журмын нэгэн хэсэг буюу өөр хоорондоо харилцан хамаарал бүхий, түүнээс улбаалан гарах, цагдаагийн албаны тухай хуулиар хамгаалагдах харилцаа бегеед олон нийтийн хэв журам буюу дээр дурьдсан явцуу утгатай дүйцүүлэн ойлгож болохоор байна. Иймд нийтийн хэв журмын ойлголт нь хүмүүсийн хоорондоо харилцах газар, өөрөөр хэлбэл олон нийтийн газартай холбоотой асуудал юм. Хууль тогтоомжид олон нийтийн газарт чухам ямар газар хамаарах талаар тусгаж ирсэн боловч нарийвчлан тодорхойлсон заалт, жагсаалт хараахан гараагүй аж.

Харин одоогийн хүчин төгөлдөр хууль тогтоомжид тухайлбал, "Захиргааны хариуцлагын тухай Монгол Улсын хууль"-ийн 21 дүгээр зүйлд "гудамж, талбай, орон сууц, нийтийн тээвэр, үзвэр үйлчилгээний болон олон нийтийн бусад газар хэрүүл, маргаан, зодоон үүсгэсэн, бусдыг өдөөн хоргоосон, айлган сүрдүүлсэн, иргэдийн амгалан

тайван байдал алдагдуулсан, олон нийтийг үл хүндэтгэсэн, үйлчилгээний болон дарааллын журам зөрчсөн"-ийг танхайрах захиргааны зөрчил хэмээн үзэж, шүүгч, сум, дүүрэг, баг, хорооны Засаг дарга, цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан захиргааны хариуцлага хүлээлгэх тухай заажээ. Энд "Олон нийтийн бусад газар" гэснээс үзсэн ч бүх олон нийтийн газрын жагсаалт биш болох нь илэрхий юм.

Хууль зүйн ном зохиолд амьдралын янз бүрийн хэрэгцээг хангах зорилготой хүмүүс хоорондоо харилцах газар нь олон нийтийн газар гэж бичиж тэмдэглэх нь олонтой.

Олон нийтийн газарт хүмүүс явах (байх), хоорондоо харилцах нь байнгын давтагдах шинжтэй бөгөөд энд зан үйлийн журам зөрчигдсөнөөс бусдын болон өөр нэг хүний, эсхүл хэсэг бүлгийн, нийгмийн эрх ашиг хөндөгдөхөд хүрдэг.

Нийтийн хэв журмын мөн чанарыг бүрэн илэрхийлэхийн тулд арга зүйн хувьд түүний дотоод бүтцийг тодруулан үзэх нь зүйтэй юм. Өөрөөр хэлбэл нийтийн хэв журмын агуулга, зорилго, зохицуулах хэрэгсэл, хэрэгжих баталгаа нь бүтцийн бүрэлдүүлбэр, мөн чанарын илэрхийлэл юм.

Нийтийн хэв журам нь төрийн байгуулал, ардчилал, өмчийн олон хэвшил, нийгэм дэг журамтай холбогдож, гишүүдийнхээ эрэлт хэрэгцээг хангах шаардлагатай нөхцөлдсөн байдгаараа материаллаг агуулгатай.

Мөн "Нийтийн хэв журам", "Нийгмийн дэг журам" гэсэн ойлголт өөр хоорондоо олон талаар ижил боловч түүний зааг ялгааг бас анхааран үзэх нь чухал.

Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлд "...нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн" гэж заасан. Энэ нь төрийн бүх байгууллагад хамааралтай, төр, захиргааны байгууллагын хамтын хүчин чармайлтаар хэрэгжих үйл явц юм.

"Нийгмийн хэв журмыг бэхжүүлэх" нь Монгол Улсын Засгийн газрын нийтлэг чиг үүрэг, хэрэгжүүлэх бүрэн эрх болох талаар Монгол Улсын Үндсэн хуулийн 38 дугаар зүйлийн 2-ын 7-д заажээ.

Эдгээрээс үзэхэд хэрэгжүүлэх субъект нь ялгаатай төдийгүй, нийгмийн дэг журам нь ергөн агуулгатай, харин нийгмийн хэв журам нь түүний доторхи бүрэлдэхүүн, тэгвэл нийтийн хэв журам нь нийгмийн хэв журмын төрөл-хэсэг мэт ойлгогдохоор ажиглагдана. Өөрөөр хэлбэл нийгмийн хэв журам нь нийтийн хэв журмаас өргөн хүрээтэй ойлголт юм.

Ер нь нийгмийн дэг журам, нийгмийн хэв журам, нийтийн хэв журам гэсэн ойролцоо утгатай социали, эрх зүйн ойлголтыг аль талаас тайлбарлахаас түүний харьцааг зөв илэрхийлэх биз ээ.

Гэвч "нийгмийн дэг журам"-ыг "төрийн дэг журам" гэж ойлгож, зөвхөн хэрэгжүүлэх субъектын талаас нь авч үзэх нь илүү оновчтой хэмээн бодно. Учир нь дээрхи "нийгмийн дэг журам" нь Монгол Улсын Үндсэн хуулийн 11 дүгээр зүйлд тусгагдан бэхжүүлсэн "төр"-д хамааралтай эрх зүйн заалт юм.

Харин нийгмийн хэв журам нь зөвхөн эрх зүйн төдийгүй, зан заншил, уламжлалын болон ёс суртахууны хэм хэмжээгээр зохицуулагддаг социали, эрх зүйн өргөн хүрээтэй ойлголт гэдгийг өмнө дурьдсан.

Тэгэхлээр, эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдаж буй нийгмийн харилцаа, түүний төрөл хэсэг буюу явцуу утгаар илэрхийлэгдэх нийтийн хэв журам нь эрх зүйн дэг журмын хүрээг тэлж, тэдгээр нь хоорондоо ихээхэн хэмжээгээр давхцана. Зан заншил, ёс суртахуун, хамтын аж байдлын хэм хэмжээгээр зохицуулагдах нийгмийн хэв журмын хүрээ нь эрх зүйн дэг журмын хүрээнээс гадуур оршино.

Эрх зүйн дэг журам, нийтийн хэв журмын хүрээ бүхэлдээ

давхцана гэж бас ойлгож болохгүй. Эрх зүйн олон харилцаа, дэг журам жишээ нь хөдөлмөрийн, иргэний эрх зүйн гэх мэт эрх зүйн харилцаа нийтийн хэв журмын хүрээнд орохгүй гэсэн хэрэг.

Эрх зүйн дэг журам нь нийгмийн хэв журмын гол хэсгийг бүрэлдүүлж, эрх зүй зүйн хэм хэмжээгээр хамгаалагдсан нийтлэг бүхий харилцаа зөрчигдсөн тохиолдолд эрх зүйн албадлагаар хамгаалагддаг, тэгвэл нийтийн хэв журам нь тодорхой нэг төрлийн харилцааг цагдаагийн байгууллагаас хууль сахиулахаар тогтоосон байна.

Эрх зүйн хэм хэмжээгээр зохицуулагдах олон нийтийн аюулгүй байдлын хүрээ ч эрх зүйн дэг журмын бүрэлдэхүүн хэсэг, нэг элемент юм.

Ийм байдлаар олон нийтийн аюулгүй байдал, нийгмийн амьдралын нийлмэл бусад хүрээн дэх жишээ нь эрх зүйн ба нийгмийн дэг журам, нийтийн хэв журмыг харьцуулан авч үзэх нь нийтийн хэв журмын ойлголт, мөн чанарыг тодруулах чухал ач холбогдолтой асуудал юм.

Нийтийн хэв журам нь хүсэл зоригоор илэрхийлэгдэх агуулгатай,

түүнчлэн нийтийн хэв журмыг хамгаалах талаасаа иргэний эрх, төр, олон нийтийн байгууллагын эрх хэмжээг төрөөс зохицуулсан хэм хэмжээ тогтоодгоороо бас эрх зүйн агуулгатай юм. Үүгээр нь нийтийн хэв журмын агуулгыг олон нийтийн газарт бүрэлдэн бий болсон нийгмийн харилцааны нэгэн тогтолцоо гэж үздэг.

Нийтийн хэв журмын зорилго нь иргэдийн амгалан тайван байдал, ая тухтай амрах, ажиллах бололцоог хангах, төр, олон нийтийн байгууллагын захиргааны үйл ажиллагааны хэвийн нөхцлийг бүрдүүлэхэд оршино.

Нийтийн хэв журам олон нийтийн газарт бүрэлдэн тогтсон нийгмийн харилцааг зохицуулагч хэрэгсэл нь зан заншил, уламжлалын, ёс суртахууны болон эрх зүйн хэм хэмжээ байдаг.

Олон нийтийн ёс суртахуун, улс төрийн нэгдэл, нийгмийн хэв журам, хүн амын үзэл бодлын тохироо, иргэдийн шударга зан үйл, ёс зүйд нийцэх итгэл үнэмшил, хүн амын эрх зүйн соёл, ухамсрын тасралтгүй өсөлт зэрэг нь нийгмийн хэв журмыг бэхжүүлэх баталгаа болно⁷¹.

⁷¹ Ж.Долгорсүрэн, Д.Булган нарын Монгол Улсын Цагдаагий эрх зүйн курс. УБ. 2014 он. 38 дахь тал

Дүгнэлт

❖ Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиудаас цагдаагийн байгууллагаас нийтийн хэв журмыг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх чиглэлээр зохицуулсан заалт бүхий 33 хууль байгаа бөгөөд хуулийн зүйл, заалтууд зөрчилдөөнгүй, бусад төрийн байгууллагуудын үйл ажиллагаатай давхардал, хийдэл байхгүй байна.

❖ Дээрх 33 хуулийг он цагийн дарааллаар авч үзвэл 1992-2022 онд батлагдсан байгаа нь энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин бүрдсэн гэж үзэж болохоор байна.

❖ Цагдаагийн байгууллагаас нийтийн хэв журмыг хамгаалах үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журмыг батлан хэрэгжүүлж байгаа нь практик үйл ажиллагаанд эерэгээр нөлөөлж байна.

Эх сурвалжийн жагсаалт

1. Эрх зүй, баримт бичиг.

✓ Монгол Улсын Үндсэн хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл., 1992., №1.

✓ Монгол Улсын Цагдаагийн албаны тухай хууль. Төрийн мэдээлэл эмхэтгэл., 2017., №8

2. Сурах бичиг, нэг сэдэвт бүтээл.

○ Долгорсүрэн.Ж, Монгол Улсын Цагдаагийн эрх зүй, УБ, 2004 он.

○ Совд.Г, Монгол Улсын Үндсэн хуулийн нэр томъёоны дагалга. УБ, 1993 он.

○ Таванжин.Д., Монгол Улсын Цагдаагийн эрх зүй. УБ., 2006 он.

○ Долгорсүрэн.Ж, Булган.Д нарын Монгол Улсын Цагдаагий эрх зүйн курс. УБ. 2014 он.